



245

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 410

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 40 дүгээр зүйлийн 40.1, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх заалтууд, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2013 оны 10 дугаар сарын 18-ны хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудад тусгай зөвшөөрлийг хавсралтад зааснаар олгосугай.
2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Я.Буянжаргал/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга /А.Эрдэнэтuya/-д даалгасугай.



Н.УДВАЛ

246

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 11 сарын 06 өдрийн
410 дугаар тушаалын
хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1	Жигүүр гранд групп ХХК “Гранд мед” эмнэлэг	Төв эмнэлгийн тусlamж үйлчилгээ
2	“Гүн тэнгэрийн нар” ХХК	Ариутгал, халдвартгүйтгэлийн бодис импортлох, ханган нийлүүлэх
3	Тунгалаг аялгуу ХХК	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, протез ханган нийлүүлэх, импортлох, худалдах
4	Экомед ХХК	Биологийн идэвхит бүтээгдхүүн ханган нийлүүлэх, импортлох, худалдах
5	Хаба Монголиа ХХК	Биологийн идэвхит бүтээгдхүүн ханган нийлүүлэх, импортлох
6	Шинжьюку ХХК	Эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэх, импортлох, худалдах, засвар үйлчилгээ
7	Сод Олз ХХК	Эмнэлгийн тоног төхөөрөмж дагалдах хэрэгсэл ханган нийлүүлэх, импортлох
8	Тимусфарма ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, импортлох